



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар 104

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1, "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээ"-ний тухай Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2022 оны 75 дугаар тогтоол, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Говь-Алтай аймгийн өмчөөс төрийн өмчид шилжүүлсэн аймгийн Засаг даргын тамгын газрын 3 дугаар байрны 580.2 м.кв талбайтай, 397,221,456.00 (гурван зуун ерэн долоон сая хоёр зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун тавин зургаан) төгрөгийн балансын үнэ бүхий хэсгийг хавсралтад заасны дагуу төрийн өмчид хүлээн авч, Говь-Алтай аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст эзэмшүүлж хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Л.Ганхуяг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны "Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай" 69 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА


Д.НАРАНГЭРЭЛ
132004806
9-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2028 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн
104... дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЭЗЭМШИЛД, АВЧ ХӨРӨНГӨД БҮРТГЭХ БАРИЛГЫН (ТАЛБАЙН ХЭМЖЭЭ 580 М.КВ) ЗААГИЙН ЗУРАГ

НЭГ ДАВХАРЫН СХЕМ ЗУРАГ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн
104 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ЭЗЭМШИЛД АВЧ ХӨРӨНГӨД БҮРТГЭХ БАРИЛГЫН (ТАЛБАЙН ХЭМЖЭЭ 580 М.КВ) ЗААГИЙН ЗУРАГ

ХОЁР ДАВХАРЫН СХЕМ ЗУРАГ

